



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 07 сарын 05 өдөр

Дугаар 0/930

Ховд

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.4, Барилгын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.6, Засгийн газрын 2021 оны 212 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрмийн 1 дүгээр хавсралтын 2 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар “Уран минж хийц” ХХК-ийн хийж гүйцэтгэсэн Шинэ хөдөө төсөл /Ховд/ 1 дүгээр багцын ажлыг хүлээн авах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн
ахлагч: З.Өмиртай

- Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын Барилга, хот байгуулалтын хэлтсийн дарга

Гишүүд: З.Батзаяа

- Мэргэжлийн хяналтын газрын эрчим хүчний хяналтын улсын байцаагч

Д.Эрдэнэбат - Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн мэргэжилтэн

Ц.Цолмонбаатар - Стандарт хэмжил зүйн хэлтсийн салбар сан хариуцсан мэргэжилтэн

Б.Түмэнжаргал - Орон нутгийн өмчийн газрын мэргэжилтэн

Б.Энхболд - Дарви сумын Засаг даргын орлогч

Л.Мөнхжаргал - Дарви сумын Засаг даргын Тамгын газрын дарга

С.Батдорж - Аймгийн Архивын тасгийн дарга

Х.Оюунбат - “Уран минж хийц” ХХК-ийн захирал

8400 01 2198

Нарийн бичгийн

дарга: Б.Жамбалдорж - Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын мэргэжилтэн

2. "Уран минж хийц" ХХК-ийн хийж гүйцэтгэсэн ажлыг захиалагчаас өгөгдсөн ажлын тоо хэмжээтэй тулган шалгаж, өмч бүртгэлд тусгаж хүлээн авах эсэх талаар шийдвэр гарган танилцуулахыг ажлын хэсгийн ахлагч (З.Өмиртай)-д даалгасугай.

3. Дээрх ажилтай холбогдолтой гарах зардлыг захиалагчийн хяналтын зардлаас гаргахыг аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга (Э.Дөлбадрал)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГЫН
ОРЛОГЧ



Т.ДЭЛГЭРСАЙХАН